

Quality is our passion ...





Агуулга

- 2** Бидний тухай
- 5** Зөвлөх үйлчилгээ
- 8** ХАБЭА-н Аутсорсингийн үйлчилгээ
- 12** Сургалтын үйлчилгээ
- 15** Төслийн удирдлага
- 17** Нөлөөллийн үйл ажиллагаа
- 19** Манай харилцагчид

Бидний тухай

Эрхэм зорилго:

Харилцагч бүрийнхээ асуудлыг ойлгож, тохирсон шийдлийг, үр нөлөөтэй хэрэгжүүлэх чадавхи бүхий олон улсад итгэмжлэгдсэн удирдлагын тогтолцоо болон мэргэжлийн баг, сүлжээтэй Дэлхийн жишигт нийцсэн байгууллага байна.

Алсын хараа:

Хариуцлагатай цйлдвэрлэл, ногоон хөгжлийг эрхэмлэгч байгууллага, мэргэжилтэн бүрийн тэргүүн сонголт.

**Дэлхийд өрсөлдөх
Монгол компанийн төлөө!**

Үйл ажиллагаа

"ОШМИ" Групп нь 2010 онд үүсгэн байгуулагдсан Монгол дахь сургалт, зөвлөх үйлчилгээний тэргүүлэх групп компани юм. Бид нийгмийн өндөр хариуцлагатай, олон улсад өрсөлдөх чадавхи бүхий тогтвортой бизнес; үр чадвар бүхий мэргэжилтнүүдийг бэлтгэх чиглэлээр сургалт ба баталгаажуулалт, менежментийн зөвлөх үйлчилгээ, ХАБЭА-н аутсорсинг, төслийн удирдлагын болон нөлөөллийн үйлчилгээ үзүүлдэг.

Монгол дахь зах зээлийн судалгааны тэргүүлэх компаниудын (MIRIM Консалтинг ХХК, 2015; MMCG ХХК, 2016) сүүлийн жилүүдэд хийгдсэн хөндлөнгийн судалгааны дүнгээр "ОШМИ" групп нь ХАБЭА-н сургалт болон олон улсын ISO стандартын зөвлөх үйлчилгээний зах зээлийг тэргүүлж байна.

Бизнесийн бүтэц

"ОШМИ" Групп нь байгуулагдсан цагаасаа хойш харилцагч, үйлчлүүлэгчдийнхээ сэтгэл ханамжид нийцсэн чанартай үйлчилгээг үзүүлж ирсэн юм. Үүний үр дүнд үйл ажиллагаа маань жил бүр өргөжин тэлж өдгөө дараах охин компаниудтайгаар үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- "ОШМИ" ХХК
- "ОШМИ Аутсорсинг" ХХК
- "ОШМИ Консалтинг" ХХК
- "Монголын Хөдөлмөрийн Аюулгүй Ажиллагаа Эрүүл Ахуйн Менежментийн Хүрээлэн" ТББ

..."ОШМИ" ХХК нь зөвлөх үйлчилгээний байгууллагуудын чадамжийн үнэлгээгээр хамгийн өндөр оноо буюу 4-с 3.2 оноо авч 1-рт эрэмбэлэгджээ...


Эх сурвалж: "Байгаль орчны удирдлагын тогтолцоо, ISO14000 стандартыг нэвтрүүлэх үндэсний стратеги 2016" 51-р хуудас

Бизнесийн чадавхи

Манай компани нь хүний нөөц, санхүү, материаллаг баазын хувьд чадавхиа тасралтгүй сайжруулж, олон улсын зах зээлд өрсөлдөхүйц байх зорилго тавин ажиллаж байна.

Одоогоор бид 15 үндсэн ажилтан, дотоод гадаадын 50 гаруй гэрээт зөвлөх, сургагч, аудитортай; хотын төвд сургалт, зөвлөх үйлчилгээний хэрэгцээнд зориулан тохижуулсан өөрийн оффистойгоор үйл ажиллагаа явуулж байна.

Хөгжлийн зураглал

2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
 "ОШМИ" ТББ Үүсгэн байгуулагдав	 "ОШМИ" ХАБЭА-н Сургалтын төв байгуулагдав	 АНУ-ын OSHAcademy-н exclusive ATP болов	 "ОШМИ" ХХК байгуулагдав  Өөрийн оффистой болов	SAFETY education "Аюулгүй байдлын боловсрол" ХМХ байгуулагдав.  Их Британийн BSI Group-тэй хамтран ажиллах гэрээ байгуулав  "ОШМИ АУТСОРСИНГ" ХХК байгуулагдав  АНХНЫ Австралийн сайн дурын ажилтнаа хүлээн авлаа	 Канадын PECB-н ATP болов  Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк TAM-BAS хөтөлбөртэй хамтарч эхлэв  Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагатай гэрээ байгуулав  Австралийн гэрчилгээт сургалтуудыг зохион байгуулах чиглэлээр Etas Group-тэй хамтран ажиллах санамж бичиг байгуулав	 Үүсгэн байгуулагчид Их Британид Мастерын зэрэг хамгаалав  Лондонд IOSH-ийн зохион байгуулсан Safety & Health Expo 2016-д оролцов  "Оюу Толгой" ХХК-н дэмжлэгтэйгээр Австралын гэрчилгээ 3 түвшний сургалтын хөтөлбөрийг боловсруулав	Oshmi Group "ОШМИ" ХХК группийн зохион байгуулалтад шилжив  "ОШМИ Консалтинг" ХХК байгуулагдав  SRK компанитай хамтран ажиллах санамж бичиг байгуулав	 "ОШМИ-ИСТ" хөтөлбөрийг эхлүүлж 3 аймагт төлөөлөгчтэй болов.  2014 оноос эхлүүлсэн "Safety Leadership" форумыг "CSR Leadership" нийгмийн хариуцлагын форум болгож өргөжүүлэн 4 дэх удаагаа амжилттай зохион байгуулав.  Австрали, Шинэ Зеландын итгэмжлэлтэй "MSCS" ХХК-тай ISO сургалтын чиглэлээр хамтран ажиллаж эхлэв.

Яагаад ОШМИ гэж ?

Зөвлөх
үйлчилгээний
захиалагчийн
дундаж үнэлгээ

4.5 [5]

ХАБЭА-н
аутсорсингийн
үйлчилгээний
захиалагчийн дундаж
үнэлгээ

4.6 [5]



Ялгаатай
салбаруудад
ажилласан
туршлага

20

Байгууллагын
захиалгат сургалтын
сэтгэл ханамжийн
түвшин

96.3%
[100%]



Зөвлөх
үйлчилгээ,
аутсорсингийн
хэрэгжүүлсэн
төслийн нийт
тоо

74

Төрчилгээжсэн сургалч,
зөвлөх, аудиторчууд



PECB



SGS

bsi.

MMCi

"ОШМИ" ХХК нь
Монгол дахь ISO-н зөвлөх үйлчилгээ
үзүүлэгч байгууллагуудыг
чадавхиараа тэргүүлж байна



2016 оны
судалгаа

Мэргэшүүлэх
сургалтын
сэтгэл
ханамжийн
түвшин



94% [100%]



Суралцагчдын
нийт тоо

13216

Олон улсын итгэмлэгдсэн
сургалтын хөтөлбөрүүд



"ОШМИ" ХХК нь Монгол
дахь ХАБЭА-н сургалтын
зах зээлд тэргүүлж байна



2015 оны
судалгаа

ЧАНАР

ТУРШЛАГА

ИТГЭМЖЛЭЛ

НЭР ХҮНД



Зөвлөх үйлчилгээний тухай

"ОШМИ Консалтинг" ХХК нь харилцагчдынхаа онцлогт тохирсон, нэгдмэл, үр ашиг бүхий менежментийн тогтолцоог бий болгох зорилготой менежментийн зөвлөх үйлчилгээг удирдлагын тогтолцооны олон улсын ISO стандартуудын шаардлагуудыг тусгасан цогц хэлбэрээр үзүүлдэг. Бид зөвлөх үйлчилгээгээ харилцагч компанийнхаа онцлог, хэрэгцээнд үндэслэн олон улсад менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг дараах гурван загвар, аргачлалуудаас сонгон ашигладаг.

1. Процесс консалтинг загвар
2. Эмч-өвчтөн загвар
3. Эксперт загвар

Санал болгож буй үйлчилгээ

1. Удирдлагын тогтолцооны олон улсын ISO стандарт нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээ:
 - Чанарын удирдлагын тогтолцоо - [ISO 9001:2015](#)
 - Байгаль орчны удирдлагын тогтолцоо - [ISO14001:2015](#)
 - Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо - [OHSAS 18001:2007 / ISO45001:2018](#)
 - Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо - [ISO22000:2018](#)
2. Менежмент, үйл ажиллагааны үр ашиг сайжруулах аргачлал нэвтрүүлэх:
 - Тэнцвэржүүлсэн үнэлгээний системийг стратеги төлөвлөлт ба гүйцэтгэл сайжруулах чиглэлээр нэвтрүүлэх (Balanced Scorecard)
 - Процессын сайжруулалт хийх
 - Кайзен систем нэвтрүүлэх
 - 5 S нэвтрүүлэх
 - Үйлчилгээний төгөлдөршил (Service Excellence)
 - Бизнесийн төгөлдөршил (Business Excellence)
 - Чанарын зардал, үр ашгийн шинжилгээ
 - 6 sigma нэвтрүүлэх
 - S&OP систем (борлуулалт, үйл ажиллагааны төлөвлөлтийн аргачлал)

Санхүүгийн дэмжлэг хэрэгтэй юу?



2014 оноос эхлэн "ОШМИ" ХХК нь Европийн Сэргээнбосголт Хөгжлийн банкны (ЕСБХБ) Бизнесийн зөвлөх үйлчилгээ (БЗҮ) хөтөлбөрт үндэсний зөвлөх байгууллагаар бүртгэгдсэн. Хэрэв танай компани манай байгууллагаас зөвлөх үйлчилгээ авах хүсэлтэй бөгөөд дараах шаардлагыг хангаж байгаа бол БЗҮ төслөөр дамжуулан ЕСБХБ-наас зөвлөх үйлчилгээний төслийн цэвэр зардлын 25-50 хувийг (дээд хэмжээ нь 10.000 евро) буцалтгүй тусламжаар авах боломжтойг дуулгахад таатай байна.

Тавигдах шаардлага:

- 500 хүртэлх ажиллагчидтай байх.
- Үндэсний эзэмшигчтэй, хамтарсан хөрөнгө оруулалттай компани бол дийлэнх хувь нь дотоодын эзэмшигчийн мэдэлд байх.
- Үйл ажиллагааны чиглэл нь банк, санхүүгийн үйлчилгээ, цэрэг дайны бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээ, мөрийтэй тоглох, тамхины үйлдвэрлэл зэргээс бусад салбаруудад байх.
- Цаашид өсөх потенциал бүхий, удирдлага нь нэр хүндтэй, бизнесийн зөвлөгөө авах бодит хэрэгцээ шаардлагатай болох нь тогтоогдсон байх.
- Төслийн нийт зардлын 25-75 хүртэлх хувийг санхүүжүүлэх чадвартай байх.

...Манай компани "ОШМИ" ХХК-аас ISO9001, OHSAS18001 стандартуудаар цогц зөвлөгөө авсан юм. Манай хоёр байгууллага жил гаруйн хугацаанд хамтарч ажилласны үр дүнд бид дээрх стандартуудаар олон улсын баталгаажилтын аудитад орж тэнцэн олон улсад хүчин төгөлдөр гэрчилгээ гардан авсандаа баяртай байна...

"Алтайн зам" ХК-ийн Аудитын газрын захирал И.ЭРДЭНЭ

Зөвлөхийн баг

Зөвлөх үйлчилгээний төслүүдэд ихэчлэн олон улсад итгэмжлэгдсэн дотоодын өндөр ур чадвартай зөвлөхүүд ажилладаг. Хэрэв харилцагч хүсэлт гаргавал бид мөн гадаад зөвлөхүүдээ багтаа ажиллуулах боломжтой байдаг. Монгол дахь албан ёсны хамтрагчийн хувьд Канадын PECB (Professional Evaluation and Certification Board), Хонг Конгийн PLC Консалтинг, Английн AM Консалтинг, Энэтхэгийн MSCS байгууллагуудтай сургалт, зөвлөх үйлчилгээний төслүүд дээр хамтран ажиллах боломжтой.

Туришлага

"ОШМИ консалтинг" ХХК нь удирдлагын тогтолцооны олон улсын ISO стандарт нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээний 30 гаруй төслийг амжилттай хэрэгжүүлээд байгаа ба инфографикийг харуулав.



Үйлчилгүлэгч байгууллагууд

	OHSAS18001 ISO14001 Нефть		OHSAS18001 Зам барилга		ISO9001 ISO14001 ISO45001 Хэвлэл
	ISO9001 OHSAS18001 Барилга		ISO9001 ISO45001 Барилгын төслийн менежмент		ISO9001 Дулаан дамжуулах
	ISO9001 ISO14001 OHSAS18001 Харуул хамгаалалт		ISO9001 ISO45001 Тавилгын үйлдвэр		ISO9001 ISO45001 Цахилгаан түгээх
	ISO9001 OHSAS18001 Зам барилга		ISO9001 Зөвлөх үйлчилгээ		ISO9001 ISO45001 Шил хийцийн үйлдвэрлэл
	ISO9001 OHSAS18001 Буяны үйлчилгээ		OHSAS18001 Мэдээлэл харилцаа холбоо		ISO9001 ISO45001 Хүнс
	OHSAS18001 Тээвэр		ISO9001 ISO14001 OHSAS18001 Зам барилга		ISO9001 ISO14001 ISO45001 Нефть
	OHSAS18001 Уул уурхай		ISO9001 OHSAS18001 Гүний барилга		ISO9001 ISO22000 Хүнсний үйлдвэр
	OHSAS18001 Хүнсний үйлдвэр		ISO9001 Даатгал		ISO9001 Харуул хамгаалалт
	OHSAS18001 Уул уурхай		ISO9001 ISO45001 Худалдаа		ISO9001 OHSAS18001 Зам барилга
	ISO9001 OHSAS18001 Тээвэр зууч		ISO9001 OHSAS18001 Зам барилга		OHSAS18001 Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэр, ферм



2

ХАБЭА-Н АУТСОРСИНГИЙН
ҮЙЛЧИЛГЭЭ

Аутсорсингийн үйлчилгээний тухай

"ОШМИ Аутсорсинг" ХХК нь 2014 онд байгуулагдсан бөгөөд компаниудад бизнесийн үндсэн үйл ажиллагаандаа төвлөрөх, хуулийн эрсдэлээ бууруулах, зардлын удирдлагаа оновчилсноор санхүүгийн үр өгөөжөө дээшлүүлэх боломжийг олгох зорилгоор үйл ажиллагаагаа явуулж байна. Бид хөдөлмөрийн аюулгүй

байдал эрүүл ахуйн чиглэлээр хуримтлуулсан туршлага болон аутсорсингийн үйлчилгээний олон улсын жишигт тулгуурлан компаниудын ХАБЭА-н ажлуудыг стратегийн, тактикийн болон үйл ажиллагааны түвшинд бүрэн буюу хэсэгчилсэн байдлаар аутсорсингийн гэрээгээр хариуцан гүйцэтгэж байна.

1. New ХАБЭА-н аутсорсингийн багц үйлчилгээнүүд


	100-аас дээш ажилтантай	50-100 ажилтантай	50 хүртэлх ажилтантай	Тодорхой хугацаатай
	ТОМ эсвэл ЭРСДЭЛ ӨНДӨР	ДУНДАЖ эсвэл ЭРСДЭЛ ДУНД	ЖИЖИГ компанид	ТӨСЛҮҮДЭД
	компанид зориулсан үйлчилгээ	компанид зориулсан үйлчилгээ	зориулсан үйлчилгээ	зориулсан үйлчилгээ
Салбарын онцлог:	- Уул уурхай, эрчим хүч, зам, барилгын салбарын буюу үйлдвэрлэлийн аюултай, хортой хүчин зүйлс бүхий ажлын байртай ААН; - Эсвэл эрсдэл харьцангуй ба боловч салбар, ажилтны тоо их байгууллагууд	- Ихэвчлэн дундаж хэмжээний даатгал, банк санхүү, худалдаа үйлчилгээний байгууллагууд; - 50 хүртэлх ажилтантай боловч эрсдэл өндөр уул уурхай, эрчим хүч, зам, барилгын салбар болон үйлдвэрлэлийн аюултай, хортой хүчин зүйлс бүхий ажлын байртай байгууллагууд	- Ихэвчлэн зочид буудал, зоогийн газар, ресторан болон бусад үйлчилгээний жижиг байгууллагууд	- Зам, барилга, телевизийн шоу нэвтрүүлэг, шоу арга хэмжээ, төрөл бүрийн кампанит ажлууд гэх мэт олон төрөл байж болно
Тулгамддаг гол асуудал, хэрэгцээ:	- ХАБЭА-н 2 ба түүнээс дээш ажилтантай байдаг ч салбар нэгж болон ажилтны тоо их; эсвэл эрсдэл ихтэй тул өдөр тутмын хяналт шаардлагатай байдгаас зэргээс хамаарч үйл ажиллагаан дахь ХАБЭА-н ажилд зарцуулагдах цаг их байдаг. Үүнээс болж үндсэн үйл ажиллагааных нь ХАБЭА-н стратеги, тактикийн удирдлагын ажлууд хоцрогдолтой болсон байдаг; - ХАБЭА-н бодлогын түвшин дэх асуудалнь дунд хугацаанд компанийг хуулийн, цаашлаад санхүүгийн эрсдэлд оруулж болзошгүй.	- ХАБЭА хариуцсан орон тооны ажилтан байдаг боловч ажлын тогтвор суурьшил муу байдаг тул байн байн ажилтан хайх хэрэгтэй болдог; - Ихэнхдээ ХАБЭА хариуцсан нэг ажилтны орон тоотой байдаг тул мэргэжлийн олон асуудал дээр өргөн цар хүрээтэй ажиллах боломжгүй байдаг, үндсэндээ үйл ажиллагааны шаардлагатай хэсэг бүрт хүрч ажиллаж чаддаггүй	- ХАБЭА хариуцсан орон тооны ажилтан байхгүй бөгөөд тийм ажилтан ажиллуулахад цалингийн зардал хүндрэлтэй байдаг; - ХАБЭА-ыг хэн нэгний ажил үүрэгт давхар хариуцуулсан байдаг ч тухайн ажилтан үүнд бодитоор анхаарал тавьж чаддаггүй	- Төслийн хугацаагаар ажиллах ХАБЭА-н мэдлэг, ур чадвартай ажилтан олоход бэрхшээлтэй байдаг; - Хүний нөөцийн бүрдүүлэлтээр ихэнхдээ туршлага багатай ХАБЭА-н ажилтнууд олддог ба төслийн удирдлагын зүгээс ажлыг нь чиглүүлэх, хяналт тавих шаардлагатай болдог
Санал болгож буй бидний шийдэл:	"SAFETY ADVISER" багц үйлчилгээ	"OUTSOURCE SAFETY" багц үйлчилгээ	"SMART SAFETY" багц үйлчилгээ	"SAFE PROJECT" багц үйлчилгээ
	- Стратеги, тактикийн түвний бодлого, тогтолцоог бий болгоход дэмжлэг үзүүлэх зорилгоор ХАБЭА-н зөвлөх, шаардлагатай бол баг ажиллуулах боломжтой; - Бид бодлого, үйл ажиллагааны түвшинд хууль, стандартын шаардлагыг хангуулж ажиллана.	- 1 ажилтны цалингаар мэргэжлийн баг ажиллана; - Танай компанид дахин ХАБЭА-н ажилтан хайх шаардлага гарахгүй.	- 1 ажилтны цалинд хүрэхгүй бага зардлаар ХАБЭА-н тогтмол хяналт, зөвлөгөө өгнө; - Та бүхэн санаа амар ажлаа хийж болно.	- Бид 1 өдрийн төсөл байсан ч ХАБЭА-н ажлыг нь хариуцаж ажиллах боломжтой; - Төслийн ажлын онцлогоос хамаарч мэргэжлийн хүн, эсвэл багийг хүссэн газар, хүссэн цагаар ажиллуулах боломжтой.

2. ХАБЭА-н аутсорсингийн хэсэгчилсэн үйлчилгээнүүд

	ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ	ХУУЛЬ ТОГТООМЖИЙН НИЙЦЛИЙН ҮНЭЛГЭЭ	ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ СУДЛАХ	БАРИМТ БИЧИГ БОЛОВСРУУЛАХ	МЭРГЭЖЛИЙН ОРЧУУЛГА, САЙЖРУУЛАЛТ
Үйлчилгээний зорилго:	Компанийн ХАБЭА-н аюулыг илрүүлж, эрсдэлийг үнэлж, тохирох хяналтын арга хэмжээг тодорхойлох.	МУ-н ХАБЭА-н хууль тогтоомжийн нийцлийн үнэлгээг байгууллагын үйл ажиллагаанд хийж зөрүүг тодорхойлон, сайжруулалтын зөвлөмж өгөх.	Үйлдвэрлэлийн осол, осолд дөхсөн тохиолдлуудыг нарийвчлан судалж, үндсэн шалтгаануудыг тодорхойлж, залруулах, дахин гарахаас урьдчилан сэргийлэх зөвлөмж өгөх	ХАБЭА-н баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийж, сайжруулах болон шинээр бий болгох баримт бичгүүдийн хэрэгцээг тодорхойлж, боловсруулах.	Олон улсын байгууллага, төрийн байгууллага болон компанийн захиалгаар стандарт, дүрэм, журмын орчуулга хийх, хянан засварлах, хуулийн нийцлийг хангах буюу МУ-ын ХАБЭА-н холбогдолтой стандарт, хууль, дүрэм, журамтай уялдуулан сайжруулах
Үйлчилгээний агуулга:	4М аргачлал 1. Man /Хүн/ 2. Media /Орчин/ 3. Machine /тоног төхөөрөмж/ 4. Management /Менежмент/ (Үүнээс гадна байгууллагын хэрэгцээг үндэслэн эрсдэлийн үнэлгээ хийх бусад 30 гаруй аргачлалаас сонгож эсвэл хослуулж ашиглах боломжтой)	1. ХАБЭА-н тухай хууль 2. Галын аюулгүй байдлын тухай хууль 3. Гамшгаас хамгаалах тухай хууль /хууль нэмэгдэж болно/	1. Осол болсон газрыг шинжилж, хамаарах нотлох баримтуудыг цуглуулна 2. Тухайн ажлын байран дахь баримт бичгүүдтэй танилцаж дүгнэлт гаргах 3. Гэрчүүдтэй уулзаж баримтжуулалт хийнэ 4. Гэмтэж бэртсэн хүмүүсээс ярилцлага авч баримтжуулна 5. Ослын гол шалтгаануудыг тодорхойлно	1. ХАБЭА-н бодлого 2. ХАБЭА-н төлөвлөгөө 3. ХАБЭА-н журмууд 4. ХАБЭА-н Заавар, зааварчилгаа 5. ХАБЭА-н Бүртгэл, маягтууд	1. Орчуулах материалын тоог тодорхойлох 2. Орчуулгын ажлыг гүйцэтгэх 3. Орчуулгыг редактораар хянуулах 4. Орчуулгыг хүлээлгэн өгөх
Үргэлжлэх дундаж хугацаа:	5-15 өдөр	5-15 өдөр	Нөхцөл байдлаас хамаарна	Баримт бичгийн тооноос хамаарна	Баримт бичгийн тоо хэмжээнээс хамаарна
Ажиллах хүний нөөц:	1-3 мэргэжилтэн /ажлын хамрах хүрээнээс хамаарна/	1-3 мэргэжилтэн /ажлын хамрах хүрээнээс хамаарна/	2 мэргэжилтэн	Баримт бичгийн тоо, шаардлагаас хамаарна	Баримт бичгийн тоо хэмжээнээс хамаарна

Туршлага

"ОШМИ Аутсорсинг" ХХК нь ХАБЭА-н аутсорсинг үйлчилгээний цогц ба хэсэгчилсэн нийт 26 төслийг амжилттай хэрэгжүүлээд байгаа инфографикийг харуулав.



Үйлчилгээгч байгууллагууд

	"SAFE PROJECT" хаяс цагийн ХАБЭА-н ажилтан ажиллуулах үйлчилгээ	"Авьяаслаг Монголчууд" шоу нэвтрүүлгийн төсөл	ГУРВАН САЙХАН ОЮУ	Баримт бичгийн боловсруулалт	Тээвэр		Төв оффисын эрсдэлийн үнэлгээ, ажлын байрны нөхцлийн хэмжилт	Нефть
	"OUTSOURCE SAFETY" хаяс цагийн ХАБЭА-н ажилтан ажиллуулах үйлчилгээ	Хөдөө аж ахуй		Баримт бичгийн боловсруулалт	Тээвэр, катеринг		Эрсдэлийн үнэлгээ	Зочид буудал
	Эрсдэлийн үнэлгээ	Даатгал		ХАБЭА, Байгаль орчны хуулийн нийцлийн үнэлгээ /Монгол, Англиар/	Засвар		Эрсдэлийн үнэлгээ, сургалт	Барилга
	Баримт бичиг боловсруулалт	Тээвэр	Атланта Энд Жи	Баримт бичгийн боловсруулалт	Хүнсний үйлдвэр		Эрсдэлийн үнэлгээ, сургалт	Эрчим хүч
	Хууль эрхзүйн нийцлийн үнэлгээ	Уул уурхай		Эрсдэлийн үнэлгээ, OHSAS18001 зөрүүний шинжилгээ	Уул уурхай		ISO9001 / ISO45001	Барилгын төслийн менежмент
	Эрсдэлийн үнэлгээ	Фермер		Эрсдэлийн үнэлгээ	Эрчим хүч		ХАБЭА-н багц үйлчилгээ	Засвар
	Эрсдэлийн үнэлгээ	Барилгын түүхий эд үйлдвэрлэл		Эрсдэлийн үнэлгээ	Худалдаа		ХАБЭА-н багц үйлчилгээ	Барилга
	Зөрүүний шинжилгээ	Барилга		Эрсдэлийн үнэлгээ	Барилгын төслийн менежмент		Эрсдэлийн үнэлгээ	Хүнд үйлдвэр
	Дотоод аудит	Хүнсний үйлдвэрлэл		Эрсдэлийн үнэлгээ	Нефть		Хууль эрхзүйн нийцлийн үнэлгээ	Боловсрол
	Эрсдэлийн үнэлгээ	Техникийн засвар	АЛТЖИН БӨМБӨГӨР	Эрсдэлийн үнэлгээ	Худалдаа		Park Place Эрсдэлийн үнэлгээ	Үл хөдлөх хөрөнгө
	Эрсдэлийн үнэлгээ, Баримт бичиг боловсруулалт, сургалт	Барилгын түүхий эд үйлдвэрлэл		Эрсдэлийн үнэлгээ, сургалт	Төмөр зам		ХАБЭА-н багц үйлчилгээ	Хуванцар цонхны бэлдэц, хуванцар хоолой



Сургалтын тухай

Манай байгууллага нь Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, ХАБЭА-н гурван талт үндэсний хороо, Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төвөөс олгогдсон тусгай зөвшөөрлийн гэрчилгээгээр дотооддоо итгэмжлэгдсэн, хууль ёсны дагуу сургалтын үйл ажиллагаа явуулж байна.

Бид ХАБЭА-н дотоодын сургалтуудыг олон улсын стандартад нийцүүлэх чиглэл баримталж ажилласны үр дүнд 2012 оноос хойш АНУ дахь ХАБЭА-н Олон улсын сургалтын байгууллага болох OSHAcademy-ын сургалтыг Монгол Улсад зохион байгуулах онцгой эрхтэй, цорын ганц, албан ёсны сургагч байгууллага болсон билээ.



ХӨДӨЛМӨР НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМ



Authorized Training Provider



ХАБЭА-н хариуцсан ажилтныг мэргэшүүлэх сургалтууд

ХАБЭА-н ажилтнуудыг дотоодын болон олон улсын хөтөлбөрүүдээр мэргэшүүлэх сургалтыг тогтмол явуулж 2571 мэргэжилтнийг бэлтгээд байна. Бид OSHAcademy-ийн дараах 6 хөтөлбөрөөр олон улсад бүртгэлтэй мэргэжилтэн бэлтгэдэг.

1. ХАБЭА-н Ажилтан /  -н ОУ-ын гэрчилгээ/ – 30 цаг
2. ХАБЭА-н Менежер /  -н ОУ-ын гэрчилгээ/ – 30 цаг
3. ХАБЭА-н Супервайзор /  -н ОУ-ын гэрчилгээ/ – 24 цаг
4. ХАБЭА-н Сургагч /  -н ОУ-н гэрчилгээ/ – 28 цаг
5. ХАБЭА-н Зөвлөлийн гишүүд /  -н ОУ-ын гэрчилгээ/ - 28 цаг
6. ХАБЭА-н Мэргэшсэн мэргэжилтэн /  -н ОУ-ын гэрчилгээ/ - 100 цаг

Монгол Улсад дэлхийн жишигт нийцсэн ХАБЭА-н сургалтыг бий болгоход үнэтэй хувь нэмэр оруулж буй танай байгууллагад амжилт хүсье! Энэхүү сургалтанд хамрагдаж байгаадаа сэтгэл хангалуун байна.

Г.Баярхүү ("Батс-Өргөө" ХХК) -н
сургалтын сэтгэл ханамжийн
судалгаанаас

Байгууллагад зориулсан ХАБЭА-н сургалтууд

Аж ахуйн нэгж байгууллагуудын захиалгаар ХАБЭА-н сургалтыг өөрийн сургалтын танхим болон захиалагчийн ажлын байранд зохион байгуулдаг. Сургалтын хөтөлбөр, агуулгыг байгууллагын хэрэгцээ, шаардлагад тохируулан хийх боломжтой байдаг. Мөн дараах жишиг хөтөлбөрүүдээр байгууллагын сургалтыг зохион байгуулж байна.

1. Ажил олгогч, захирлуудад зориулсан хөтөлбөр – 2-6 цаг
2. Ахлах ажилтнуудад зориулсан хөтөлбөр – 4-14 цаг
3. Шинэ ажилтнуудад зориулсан хөтөлбөр – 4-10 цаг
4. Нийт ажилтнуудад зориулсан хөтөлбөр – 4-17 цаг
5. Химийн бодис, Даралтат сав, Цацраг, Өргөн тээвэрлэх машин, төхөөрөмжийн сургалтууд - 4-10 цаг
6. Эрсдэлийн үнэлгээ -5-15 цаг (UNO-н зөвшөөрөлтэй)
7. Байгаль орчны менежмент - 10-40 цаг (Trevor Price-ийн зөвшөөрөлтэй)

Удирдлагын тогтолцооны ISO олон улсын стандартын хэрэгжүүлэгч, аудиторын сургалтууд

Бид удирдлагын тогтолцооны ISO-н дараах стандартуудаар дотоодын болон олон улсын гэрчилгээт ахлах хэрэгжүүлэгч, дотоод аудитор, ахлах аудиторын сургалтуудыг зохион байгуулж байна.

1. Чанарын удирдлагын тогтолцооны ISO9001:2015 стандартын сургалтууд

- Танилцуулах сургалт /Oshmi-н гэрчилгээ/ – 2 цаг
- Дотоод аудитор /Oshmi-н гэрчилгээ/ - 24 цаг
- Ахлах хэрэгжүүлэгч /PECB-н ОУ-ын гэрчилгээ/ - 40 цаг
- Ахлах аудитор /PECB-н ОУ-ын гэрчилгээ/ - 40 цаг

2. ХАБЭА-н удирдлагын тогтолцооны ISO45001:2018 стандартын сургалтууд

- Танилцуулах сургалт /Oshmi-н гэрчилгээ/ – 2 цаг
- Дотоод аудитор /Oshmi-н гэрчилгээ/ - 24 цаг
- Ахлах хэрэгжүүлэгч /PECB-н ОУ-ын гэрчилгээ/ - 40 цаг
- Ахлах аудитор /PECB-н ОУ-ын гэрчилгээ/ - 40 цаг

3. Байгаль орчны удирдлагын тогтолцооны ISO14001:2015 стандартын сургалтууд

- Танилцуулах сургалт /Oshmi-н гэрчилгээ/ – 2 цаг
- Дотоод аудитор /Oshmi-н гэрчилгээ/ - 24 цаг
- Ахлах хэрэгжүүлэгч /PECB-н ОУ-ын гэрчилгээ/ - 40 цаг
- Ахлах аудитор /PECB-н ОУ-ын гэрчилгээ/ - 40 цаг

ХАБЭА-н ажилтныг
мэргэшүүлэх
сургалтын төгсөгч

2921



Байгууллагын
ХАБЭА-н
сургалтанд
хамрагдсан хүн

10295

Сургалт авсан
байгууллагын тоо

650



Салбарын
тоо

20

Голлох 3
салбар

**Уул уурхай
Барилга
Үйлдвэр**





МОНГОЛ УЛСАД ХАБЭА-Н
УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООНЫ
MNS OHSAS18001:2012
СТАНДАРТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
АНХНЫ СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА
**ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ**

WE OFFER SKILLS TO PROSPERITY

Ахуйн өдөр





“CSR LEADERSHIP” Бизнес удирдагчдын форум

"Бизнес Удирдагчдын Форум" нь 2014 оноос хойш жил бүр зохион байгуулагдаж байна. Өмнөх жилүүдэд "Аюулгүй байдал, эрүүл мэндийн" манлайлал, менежментийг сурталчлах зорилготойгоор зохион байгуулагдаж байсан тус форум нь 2018 оноос "Байгаль орчин, Хүнсний аюулгүй байдал, Мэдээллийн аюулгүй байдал, Компанийн нийгмийн хариуцлага, Нийгмийн инноваци ба энтрепренершип" зэрэг бусад чухал сэдвүүдийг хамран өргөжсөн юм. Орчин үед нийгэмдээ хариуцлагатай бизнес эрхлэх нь жинхэнэ манлайлагчийн дүр төрх болоод байгаа тул нийгмийн хариуцлагын үзүүлэлт тус бүрт манлайлж буй компанийн дээд удирдлагуудыг энэхүү форумд оролцуулж мэдлэг, туршлагаа солилцох боломжийг бүрдүүлээ.

- **2014** оны форум нь "Эрүүл аюулгүй ажлын байр" нэртэйгээр гүйцэтгэх удирдлагуудад компанийн удирдлагын тогтолцооны ач холбогдлыг таниулах зорилготой байсан. Нийгмийн Даатгалын Ерөнхий Газар, Өргөн Тээвэрлэх Машин Төхөөрөмж Үндэсний Холбоо ТББ, East Maven компаниуд зохион байгуулалтанд оролцож 200 гаруй захирал хамрагдсан.
- **2015** онд форумыг хөнгөн үйлдвэрлэлийн салбарынхан руу илүү төвлөрүүлэн хийсэн ба гол зохион байгуулалтад Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар, Монголын Даатгагчдын Холбоо ТББ, Хаан даатгал, MCS Соса компаниуд оролцсон.
- **2016** онд форумыг эмэгтэй удирдагчдын манлайлал сэдвийн дор Монголын Бизнесийн Зөвлөл, МҮХАҮТ, KOICA Монгол ОУ-ын байгууллага, Азийн сан зэрэг байгууллагуудын дэмжлэгтэйгээр зохион байгуулсан.
- **2018** онд форумыг "CSR Leadership 2018" нэрийн дор "Оюу Толгой" ХХК, "BCI" ХХК, "Сансар" хүнсний худалдааны сүлжээ компаниудын санхүүгийн дэмжлэгтэйгээр зохион байгуулсан. Мөн ХНХЯ, УУХҮЯ, БОАЖЯ, МХЕГ, МҮХАҮТ, Монголын бизнесийн зөвлөл зэрэг байгууллагууд дэмжиж ажилласан бөгөөд Оюу Толгой, Алтан Жолоо Групп, Монгол Такс, Терра Экспресс, Хаан банк, Хас банк, Компанийн засаглалн хөгжлийн төв, УУХҮЯ, Дэлхийн зөн, МХЕГ, Мобиком, БОАЖЯ нийгмийн хариуцлагын чиглэлээр илтгэл хэлэлцүүлсэн.

"CSR LEADERSHIP" Сэтгүцүл



ОШМИ нь аж ахуйн нэгж, олон нийтийн нийгмийн хариуцлагын талаархи боловсролыг дээшлүүлэх, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн, төрийн бус, хувийн, олон улсын байгууллагуудын мэдлэг, мэдээлэл, шилдэг туршлагаудыг дотоод болон олон улсад сурталчилан таниулах, тэдний хамтын ажиллагааг дэмжих зорилготой "Нийгмийн хариуцлагын манлайлал" /CSR Leadership/ сэтгүүлийг эрхлэн гаргаж байна.

“CSR LEADERSHIP” аялал Нийгмийн хариуцлага, менежментийн шилдэг туршлага, аялал

ОШМИ нь харилцагч байгууллагууд болон суралцагч нартаа менежментийн тогтолцоо болон манлайлал, соёлын өндөр түвшинд хүрсэн байгууллагуудын ажлын талбарт зочилж, баг, хамт олонтой нь танилцан туршлага хуваалцах боломжийг олгож байна. Бид менежментийн туршлага судлах аялалыг дотоодод зохион байгуулаад зогсохгүй мөн Япон, БНХАУ, Хонгконг, БНСУ, Англи, Герман зэрэг гадаадын өндөр хөгжилтэй олон оронд зохион байгуулах боломжтой.



Ёс зүйн код

Шударга байдал: Үнэнч шударга байх, хуулийг мөрдөх, сонирхлын зөрчилгүй байх

Ур чадвар: Ажлаа гүйцэтгэх хангалттай ур чадвартай байх, мэргэжлээ тогтмол сайжруулах, харилцагчиддаа ур чадвараа мэдээлэх

Хүндлэл: Мэргэжлийн салбарын толгой байгууллагуудынхаа тунхаг, журам, дүрмийг мөрдөх, бусдын эрх эрх чөлөөг хүндэтгэх

Үйлчилгээ: Мэргэжлийн ажлаа цаг хугацаанд нь гүйцэтгэх, үйлчилгээнийхээ түвшинг тохируулах бөгөөд үүнээс хүлээж буй харилцагчдынхаа хүлээлтийг хүндэтгэх

Туслалцаа: Мэргэжлийн салбартаа шинээр элсэж байгаа нөхдөө мэргэжлийн түвшинд өсч, хөгжихөд нь туслах

Удирдлагын нэгдмэл тогтолцоо

ОШМИ нь цйл ажиллагаандаа чанар, байгаль орчин, ХАБЭА-н удирдлагын нэгдмэл тогтолцоог PAS 99 стандартын дагуу нэвтрүүлэн хэрэгжүүлдэг. Ингэснээр бид цйл ажиллагааныхаа чанарыг удирдах явцдаа ХАБЭА болон байгаль орчны эрсдэлийг үнэлж, хянах бололцоог бүрдүүлсэн.



© 2018 OSHMI LLC
All rights reserved

